

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН
АЛБАН БИЧИГ ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭ
/2021.06.24-2021.09.24/**

2021 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр

Багануур дүүрэг

“Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-т 2021 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн байдлаар нийт 134 албан бичиг ирснээс, хариутай бичиг 66, хариугүй бичиг 68 байгаагаас Удирдлагад 5, Захиргааны албанд 100, Үйлдвэрлэл, технологийн албанд 29 албан бичиг хуваарилагдан тус тус шийдвэрлэгдсэн. Мэргэжилтнүүд хариуцсан үйл ажиллагааны чиглэлээр өөрсөддөө хуваарилагдсан албан бичгээ түргэн шуурхай, чанартай шийдвэрлэж байна.

Албан бичгийн эхийг eDoc программаар боловсруулж хэвшсэн. Албан бичгийн шийдвэрлэлтэд eDoc программын модулиудыг (эргэн танилцуулах, эргэн танилцуулах хэлбэр сонгох, хариутай бичгийн хариу сонгох, хамтран шийдвэрлэх) бүрэн ашиглахыг зорьж байна. Хариутай бичгийн шийдвэрлэлт 98.77% (1 бичгийн холбогдох баримт материалыг хариуцсан мэргэжилтэн боловсруулж байна.), нийт ирсэн бичгийн шийдвэрлэлт 100%-тай байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 3.12 хоног.


Нийслэлийн Архивын газраас өгсөн чиглэлийн дагуу, Э-токен төхөөрөмж авахад шаардлагатай бичиг баримтуудыг зааврын дагуу бүрдүүлж Газрын дарга болон Бичиг хэрэг, архив, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн нар Үндэсний Дата төвийн баталгаажуулсан 2 тоон гарын үсгийн гэрчилгээг хүлээн авч үйл ажиллагаанд ашиглаж байна. Тоон гарын үсгээр илгээгдэж буй баримт бичгүүдийг хэвлэн авч, ХУУЛБАР ҮНЭН тэмдгээр баталгаажуулан ашиглаж байна.

Манай байгууллагаас 2021 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн байдлаар харилцан холбоотой ажилладаг яам, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, аж ахуйн нэгж, албан байгууллагууд руу нийт 129 албан бичиг явуулсан байна.

Албан бичгийн шийдвэрлэлтийг 2021 оны 01-03 дугаар улирлын байдлаар харьцуулан графикаар харуулав.

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН
АЛБАН БИЧИГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ**

/2021 оны 01 - 03 дугаар улирлын албан бичгийн шийдвэрлэлтийг харьцуулахад/




“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН
АЛБАН БИЧГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ


/2021 оны 01 - 03 дугаар улирлынхыг харьцуулахад,
тоон үзүүлэлтээр/

№	Нийт ирсэн бичиг	Хариутай бичгийн тоо	Хариугүй бичгийн тоо	Шийдвэрлэлтийн дундаж хугацаа/хоног	Явуулсан бичиг
2021 оны 1-р улирал	53	23	30	2.18	39
2021 оны 2-р улирал	51	27	24	3.76	52
2021 оны 3-р улирал	47	25	22	3.57	33

Албан бичгийг хамгийн боломжит богино хугацаанд, чанартай шийдвэрлэхийг зорьж байгаа бөгөөд хариутай бичгийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа өмнөх оны мөн үед 3.02 байсан бол энэ онд 3.12 хоног байна.

Албан бичгийн шийдвэрлэлтийн зөрчил, хугацаа хэтэрч хаагдаагүй болон хугацаа хэтэрч хаагдсан албан бичиг байхгүй.

ХЯНАСАН:  Э.ЭНХЗАЯА
“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК”
ОНӨТҮГ-ЫН ЗАХИРГААНЫ АЛБАНЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

ТАЙЛАН ГАРГАСАН:  М.МӨНХДУЛАМ
БИЧИГ ХЭРЭГ, АРХИВ, ГАДААД
ХАРИЛЦАА ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН